

ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

ЛЕНИНТЭЙ АНХ УУЛЗСАН МИНЬ

Лениний тухай **Сен Катаяма***-гийн
дурдатгал

Би Лениний нэрийг 1917 онд Оросод эргэж ирж байсан тэр үед нь сонсож билээ.

Тэр үед II интернационалаар удирдуулж байсан Америк, Английн социалист сонин түүний нэрийг гаргах талаар ихээхэн хойрго байв. Ленинийг Швейцараас буцаж ирээд Петроградын хувьсгалт хөдөлгөөний удирдагч болсоны дараа Америкийн социалист намын «Нью-Йоркэр» хэмээх сонинд «Ленин бол анархист» гэж мэдээлж байсан юм. Энэ нь тухайн үед Америкийн социалистуудын дунд н. Ленинийг мэддэггүй байсныг харуулж байна. Мөн түүнчлэн н. Лениний удирдах үүрэг гүйцэтгэж байсан Цимервальд ба бусад зарим газарт болж байсан зөвлөлгөөний талаар ч иймэрхүү мэдээлэл байсан ажээ. Эдгээр түүхт бага хурлын талаар Америк дахь жирийн сонин ч атугай социалист сонинуудад ч огт мэдээлээгүй өнгөрчээ. Гэтэл удалгүй Нью-Йоркт «Зөвлөлтийн элчин консул» байгуулагдсаны улмаас Октябрийн хувьсгалын тухай өгүүллүүдийг хүмүүс олж уншдаг болж Октябрийн ялгуусан хувьсгалын зохион байгуулагч бөгөөд удирдагч болох Лениний нэрийг миний бие ч гэсэн мэддэг болов. 1921 оны 10-р сард миний бие Ленинтэй уулзах болсон тэр цагт уулзалтын талаархи бэлтгэл надад хангагдаад байсан юм. Би уулзах гэж байгаа хүний тухай бараг л бүгдийг мэдчихсэн байлаа.

Шинэ эдийн засгийн бодлого тунхагласны дараах анхны их хурал болох зөвлөлүүдийн IX их хурлын үед би анх удаа н. Ленинтэй уулзсан юм. Тухайн үед олон улсын байдал маш хурц байсан юм. Зөвлөлт засаг Женевийн зөвлөлгөөнд оролцохоор шийдвэрлээд байсан, гэтэл империалист Япон алс дорнотоос Зөвлөлт холбоот улсыг заналхийлэхээр завдаж байв. Вашингтоны зөвлөлгөөн хараахан дуусаагүй байлаа. Зөвлөлт улсын дотор улс төрийн талаар ч гэсэн энэ их хурал чухал үүрэгтэй байв. Зөвлөлт Орос улс өлсгөлөнгийн хүнд бэрх цагийг дөнгөж даван туулаад байсан цаг билээ. Миний анх харсан Москва бол коммунизм хэрхэн байгуулах асуудлыг дайны хүнд үед шийдэж, дотоодын дайсны хүнд бэрхшээлийг арилгаж байсан цаг байв. Шинэ эдийн засгийн бодлогын үр дүн хараахан гараагүй байлаа. Хэдий тийм боловч Их театрын суудлыг дүүрэн эзэлсэн их хурлын төлөөлөгчид баяр бахдалтай, ирээдүйдээ итгэл төгс байцгаасан юм. Саявтархан бид Октябрийн хувьсгалын 10 жилийн ойг ёслон тэмдэглэцгээв. Одоо бол бид тэр үеийн тэдгээр хүмүүсийн баяр бахархал нь уг үндэсгүй зүйл биш байв гэдгийг ойлгож байна.

*Японы коммунист, Коминтерний гүйцэтгэх хорооны гишүүн ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтний нэг. Тэрээр 1859 онд Японы Окаяма мужийн тариачны гэр бүлд төржээ. 1918 онд Америк дахь коминтерний секцийн даргаар томилогдон Мексикт очиж ажиллаад 1921 онд эргэн ирж түүнээс хойш 74 нас хүртлээ коминтернд ажиллаж байжээ. (орч).

Намайг Их театрын индэр дээр гарах үед хурлын танхим туйлын нам гүм болоод байв. Юу гэвэл удахгүй Ленин үг хэлнэ гэж зарлагдаад байсан юм. Их хуралд хэдэн минут үг хэлэх завшаан надад тохиолдож хурлын төлөөлөгчдөөс халуун талархалыг хүлээж билээ. Миний дараагаар нэг герман нөхөр үг хэлэв. Түүний хэлсэн үгийг маш түргэн орчуулж дуусгав. Хүмүүс Лениний гарч ирэхийг тэсч ядан хүлээцгээж байлаа. Тэгтэл Ленин индэр дээр гарч ирэхэд сонсогчид цөм суудлаасаа босч нижигнэтэл алга ташицгаав. Ленин үг хэлж эхлэв үү үгүй юу дахиад л хүчтэй алга ташилтаар түүний үгийг тасалдуулав. Тэрбээр маш энгийн бөгөөд ямар ч гоёж чимсэн үг үгүйгээр ярьж билээ. Хүмүүс яриангүй гоц анхааралтай сонсож байв. Тэр 3 цаг гаруй илтгэсэн боловч түүний нүүр царайд ч, илтгэлд нь ч өчүүхэн төдий атугай ядарсан шинж тэмдэг байгаагүй. Хүмүүс түүний хэлсэн үг нэг бүрийг шуналтайгаар сонсож байв. Түүнд хүмүүсийг өөртөө татах онцгой чадал байсны дээр хүмүүсийн анхаарлыг ч өөр рүүгээ хандуулах чадвартай байна гэдгийг би мэдэв. Тэр ямар нэгэн маяглах хөдөлгөөн гаргадаггүй бөгөөд дууныхаа өнгийг ч өндөр нам болгодоггүй намуухан энгийн ярианд нь танхим дотор чимээ аниргүй болж бүгдээр амьсгаа даран сонсоцгоов. Тэр өөрийнхөө илтгэлийг дуусгахад бүх төлөөлөгчид нэг хүн шиг суудлаасаа зэрэг босоцгоож «интернационал»-ийг дуулан түүнийг үдэж билээ. Ийнхүү зөвлөлүүдийн IX их хурал хаасан юм.

Алс дорнодын хөдөлмөрчдийн их хурлын үеэр

Би хоёр дахь удаагаа Ленинтэй Алс Дорнодын хөдөлмөрчдийн их хурлын үеэр нэг орой уулзаж билээ. Их хурлын тэргүүлэгчид н. Ленинийг нэг зөвлөлгөөнд үг хэлэхийг урьсан байжээ. Яг тэр үед Ленин өвчтэй байсан учир гадагшаа гарч болохгүй байлаа. Иймээс Ленин олон группын нөхдийг Кремль дахь өөрийнхөө өрөөнд уулзаж ярилцахаар урьжээ. Бид энгийн нэгэн өрөөнд орцгоолоо. Нилээд том тасалгаа байсан боловч энгийн хогшил тавилгатай байв. Том дугуй ширээг тойруулж, суухад эвтэйхэн зөөлөн болон түшлэгтэй сандлуудыг тавьжээ. Энд хэдэн минут хүлээж байтал удсан ч үгүй н. Ленин маш яарсан байдалтай өрөөнд орж ирэв. Бид цөм босч түүнтэй гар барьцгаалаа. Энд байсан нэг орос нөхөр биднийг Ленинтэй танилцууллаа. Бид 30-аад хүн байлаа. Алс дорнодын хувьсгалт хөдөлгөөний төлөөлөгч болох Солонгос, Монгол, Хятад, Ява, Япон зэрэг хүмүүс байсан юм. н. Ленин бидэнтэй нэг бүрчлэн ярилцаж тухайн улс орон бүрийн хувьсгалт ажилчны хөдөлгөөний онцлог нөхцөл хийгээд алс дорнодын ажилчны хөдөлгөөний талаархи ерөнхий асуудлыг хэлэлцэв. Тэрээр их хурлын төлөөлөгч бидэнд тус тусын төлөөлсөн олон улсын хувьсгалт хүчийг төвлөрүүлэн нэгтгэхийг уриалж билээ.

Миний хувьд гэвэл Коминтерний III их хуралд тавьсан илтгэлийн талаар санал нэгтэй бүрэн дэмжиж байгаагаа илэрхийлэв.

Тэр тухай миний бичсэн өгүүлэл «Ка И» хэмээх сэтгүүлд хожим нийтлэгдсэн байв. Түүндээ би империалист японы эсрэг алс дорнодын хувьсгалт ажилчдын нэгдсэн фронт байгуулах чухал шаардлагатай болохыг нотолсон юм.

н. Ленин болон бидний хоорондох ярилцлага цаг гаруй үргэлжлэв. Тэр үдэш Ленин маш өндөр сэтгэгдэлтэй байлаа. Биеийн байдал нь сайн бололтой. н. Ленин, төлөөлөгч бүрийн хэлсэн үгийг маш анхааралтай сонсож байсан нь бидэнд гойд сайхан сэтгэгдэл төрүүлж

билээ. Тэр англи хэлэнд гарамгай сайн байсан. Тиймээс ч хүмүүстэй харилцан сайн тайлбарлан ярилцаж чаддаг байв. Бид түүний зочин нь болж гэр орондоо л байгаа юм шиг мөртлөө хэзээ язааны хуучин найз нөхөд шиг л сэтгэгдэлтэй байцгааж билээ. Ленин найрсаг, журмын нөхдийн бялхам сэтгэлээр зөвлөлдөн ярилцах тийм нөхцлийг бүрдүүлж, тийм байдалд бид маш чухал улс төрийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байсан нь туйлаас тааламжтай байлаа. Чухамхүү үүнд л түүний гарамгай зохион байгуулагч, удирдагчийн гавъяа чадал оршиж байгаа юм.

Ийм ахар богино хугацааны уулзалтын үеэр н. Ленин төлөөлөгчдөд хандан олон чухал зүйлийг анхааруулж, сэнхрүүлж өгсөн юм. Бид түүнийг хэт ядраачихийг хүсээгүй учир төдхөн түүнтэй салах ёс гүйцэтгэлээ. Тэр орой би түүнтэй гар барих ялдамдаа эрүүл мэндээ эрхэмлэж, түргэн эдгэрэхийг хүссэн сэтгэлээ илэрхийлэхэд тэрээр «Миний өвчин тийм ч хүнд биш», «Бид ажиллахгүй бол болохгүй байна» гэж хэлээд салцгаасан юм.

Коминтерний IV их хурал

Би Лениний гарыг дахин нэг удаа атгалаа. Тэр бол Коминтерний IV их хурлын үед байв. Ленин тус их хурлын нэгэн зөвлөлгөөнд үг хэлэхээс нь өмнөхөн болж билээ. Тэр түүний өмнөх хэдэн долоо хоногийн турш өвчтэй байсан болохоор зөвлөлгөөнд арай гэж хүрэлцэн иржээ. Их хурлын хэлэлцэх асуудал бол удаа дараагийн их хурлаас гаргасан шийдвэрүүдийг улам нарийн нягт болгож хэвшүүлэхэд оршиж байв. Энэ их хурлаар Коминтерний программыг батлахаар шийдвэрлэж байсныг н. Лениний дэвшүүлсэн саналын дагуу хойшлуулж дараачийн их хурлаар хэлэлцүүлэхээр тогтов.

Энэ бол 1922 оны 11-р сарын дундуур байв. Ленин Кремлийн их ордны Андреевийн уужим том танхимийн индэр дээр гарч ирээд хурлын тэргүүлэгчидтэй гар барин мэндлээд тэр дороо л хүмүүсийн зүг хандан үг хэлж эхлэв. Тэрбээр герман хэлээр бараг нэг цаг гайхамшигтай сайхан ярьж билээ. Илтгэлийн сэдэв нь «Оросын хувьсгалын 5 жилийн ой» гэдэг нэртэй байлаа. Тэр хэдэн удаа цагаа гаргаж харав. Тогтоогдсон цагтаа багтааж илтгэлээ дуусгахыг яарч байсан бололтой. Түүний байдал туйлын их ядарсан шиг харагдав. Өвчин нь хүндэрсэн мэт боловч тэр бишрэм сайхнаар илтгэж байв. Илтгэл дууссангуут мөн л хуучин шиг нижигнэсэн алга ташилт удаан үргэлжлэв. н. Ленин хурлын тэргүүлэгчидтэй 10-аадхан минут хамт сууж тулгамдсан хэд хэдэн асуудлыг шийдвэрлэв. Тэгээд тэр төдхөн гэртээ буцав. Энэ бол миний Ленинийг харсан эцсийн удаа байлаа.

Ленин бол эдүгээ хүртэл миний мэддэг хамгийн сэтгэл татах чадал бүхий хүн байж билээ. Түүний томъёолон хэлдэг үг, хүнтэй ярих яриа нь шууд шулуун байсны дээр зөвлөлдөөн хэлэлцэхгүйгээр шийдвэрлэж болохгүй ямарваа асуудалд чин үнэн сэтгэлээсээ ханддаг байв. Ленинтэй ярилцаж байхад түүний ярианы өнгөнд ярилцаж буй тэр хүндээ дэлхийн хувьсгалын удирдагчтай ярилцаж байна гэсэн сэтгэгдэл төрүүлэх гэсэн янз өчүүхэн төдий ч байдаггүй байсан юм. Тэрээр хүнийг өөртөө итгүүлж илэн далангүй ярилцуулж чадах тийм онцгой чадварыг эзэмшсэн хүн байлаа.

Лениний тухай дурсамж сэтгэгдлээ үлдээсэн нөхдүүдийн хүн нэг бүрийн дурьдатгал бол хожмын хойч үеийн хүмүүст коммунизм ба социалист хувьсгалын жолоодогч аугаа их онолч түүний эрхэм нандин зан чанарыг ойлгуулах боломж бий болгох нь дамжиггүй. Бид зөвхөн Ленинизмыг судлаад зогсохгүй, энэ сургаалыг үүсгэн гаргасан

хүнийхээ амьдралыг судлахгүй байж болохгүй юм. Ленин ба Ленинизмийг судлах явдал бол бид тэрхүү жолоодогчийн үйл хэргийг цаашид үргэлжлүүлэх явдалд тус дөхөм үзүүлэх билээ.

Сен Катаяма. Бүтээлийн эмхэтгэл Токио.
1960 он. III боть. 168—173-р тал.
Япон хэлнээс орчуулсан **Ц. Хандсүрэн.**